

НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙН ҮНЭ ЦЭН

Мэдээлэл хариуцагч нарт зориулсан сургалт, хэлэлцүүлэг

НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙН ҮНЭ ЦЭН

Зорилго: Төрийн байгууллагад цугласан мэдээллийг нээлттэй өгөгдөл болгож, түүний үр ашгийг нэмэгдүүлэх

Хэзээ: 2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 09:00 цагт

Хаана: Блю Скай зочид буудлын 2 давхарт, Эмералд танхим

Оролцогч: Нээлттэй өгөгдөл хариуцсан төрийн байгууллагууд

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулж уг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан мэдээлэл хариуцагч нь өөрийн байгууллагын нээлттэй өгөгдлийг цахим хуудсаараа болон төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системд нийтлэх үүрэг хүлээсэн.

Нээлттэй Нийгэм Форум болон Тунгаахуй өгөгдлийн урлан нь нээлттэй өгөгдлийн салбарын хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор 2022 оны 4 дүгээр сараас эхлэн “Нээлттэй өгөгдөлд суурилсан нээлттэй засаглалыг бэхжүүлэх нь” төслийг хэрэгжүүлж эхэлсэн ба Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Үндэсний статистикийн хороотой хамтран мэдээлэл хариуцагч байгууллагуудад нээлттэй өгөгдлийн үнэ цэн, түүнийг боловсруулахад анхаарах асуудлын талаар мэдээлэл солилцох сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Технологийн хөгжил, цахимжилт хурдсахын хэрээр их хэмжээний өгөгдөл үүсэж, түүнд суурилсан олон шинэ боломжууд бий болж байна. Тэр дундаа төрийн байгууллагуудад бизнес, хүн амыг бүхэлд нь хамарсан өргөн цар хүрээтэй, олон төрлийн, анхдагч өгөгдлүүд цугларч, тэрхүү өгөгдлийн урсгалыг зөв чиглүүлэн, чанартай өгөгдөл үүсгэж, бодитойгоор ашиглах замаар үнэ цэнийг нь нээн, эдийн засгийн эргэлтэд оруулах нь чухал юм.

Төрийн байгууллагуудад цугларсан мэдээллийг нээлттэй өгөгдөл болгосноор инновацыг дэмжих, эдийн засгийн өсөлтийг хангах, шинэ ажлын байр бий болгох, төрийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах, төрийн үйлчилгээг шуурхай, ил тод, хүртээмжтэй болгох, үр ашгийг нь нэмэгдүүлэх ач холбогдолтой.

НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙН ҮНЭ ЦЭН

Мэдээлэл хариуцагч нарт зориулсан сургалт, хэлэлцүүлэг

2022.09.22 | Улаанбаатар хот

09:00 – 09:10 | НЭЭЛТ

Н.Учрал | Цахим хөгжил, харилцаа холбооны сайд
Б.Батдаваа | Үндэсний статистикийн хорооны дарга

09:10 – 10:00 | ИЛТГЭЛҮҮД

- Нээлттэй өгөгдөл, түүний ач холбогдол
Ш.Ариунболд | ҮСХ-ны Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын дарга
- Нээлттэй өгөгдлийн хэрэглээ, олон улсын болон МУ-н туршлага
Б.Дэлгэрмаа | Олон улсын санхүүгийн корпорацийн “Хөгжлийн төлөө ил тод байдал” хөтөлбөрийн зохицуулагч
- Нээлттэй өгөгдөл үүсгэх, нийтлэх тухай
Г.Амарсанаа | МУИС-ийн Мэдээлэл, компьютерийн ухааны тэнхимийн дэд профессор, Монголын дата клубын Өгөгдлийн бодлогын зөвлөх

10:00 – 10:20 | ЦАЙНЫ ЗАВСАРЛАГА

10:20 – 11:20 | ИЛТГЭЛҮҮД

- ҮСХ-ны мета өгөгдөл үүсгэж буй туршлага
О.Мандахзориг | ҮСХ-ны ТӨШГ-ын Хүн ам, орон сууцны тооллогын хэлтсийн дарга
- Нээлттэй өгөгдлийн платформын хэрэглээ (“Дижитал аймаг” төсөл)
Ю.Буд | Ай Си Ти Групп ХК-ийн Бүтээгдэхүүн хариуцсан захирал
- Нээлттэй өгөгдлийг ашиглан бизнесийн үнэ цэн бүтээх нь
О.Золбаяр | Мезорн ХХК-ийн Гүйцэтгэх захирал
- Нээлттэй өгөгдлийн бүтээгдэхүүн хөгжүүлэх нь
Э.Тунгалаг | Тунгаахуй өгөгдлийн урлангийн Үүсгэн байгуулагч

11:20 – 11:50 | АСУУЛТ, ХАРИУЛТ

11:50 – 12:00 | ХААЛТ

Д.Энхцэцэг, Нээлттэй Нийгэм Форумын Засаглалын хөтөлбөрийн менежер